

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХХААГ

ХХААГ-ЫН 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМД  
БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЭЛД ДОТООД АУДИТ ХИЙСЭН МАТЕРИАЛ

2022 он

Дотоод хяналт шалгалтад хамрагдсан объект :

ХХААХҮЯам болон байгууллагын вэб сайт, ахлах нягтлан бодогч Б.Мэндбаяр

Дотоод хяналт шалгалтын хугацаа : 2022.04.05 - 2022.04.11

Дотоод хяналт шалгалтын багийн ахлагч : С.Мөнхжаргал

Дотоод хяналт шалгалтын багийн гишүүд : Э.Түвшинзаяа, А.Баярмаа

ТОВЪЁОГ

1.Удирдамж

2.Танилцуулга

3.Дотоод хяналт шалгалтын дүнд өгсөн дүгнэлт

4.Дотоод хяналт шалгалтад хамруулсан баримт бичгүүд

## ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА:

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар байгууллагын шилэн дансны цахимд байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийсэн тайлан

Дотоод хяналт шалгалт хийх үндэслэл:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ХХААГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 02 тоот удирдамжийн хүрээнд шалгав.

Шалгалтыг дотоод хяналт шалгалтын багийн ахлагч С.Мөнхжаргал, гишүүн

Э.Түвшинзаяа, А.Баярмаа нар 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаанд гүйцэтгэв.

Дотоод хяналт шалгалтад ХХААХҮЯам болон байгууллагын вэб сайтад тавигдсан шилэн дансны 1 дүгээр улирлын цахим мэдээлэл, ахлах нягтлан бодогч Б.Мэндбаярыг хамруулав.

## ХХААГ-ЫН 2022 ОНЫ 1-Р УЛИРЛААР ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМД БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЭЛД ДОТООД АУДИТ ХИЙСЭН ТАЙЛАН

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолыг үндэслэн байгууллагын 2022 оны 1 дүгээр улирлаар Шилэн дансны цахимд байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийв.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын шилэн дансны цахим мэдээллийг “Шилэн дансны тухай хууль”-ийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дахь заалтын дагуу шалгасан.

Байгууллагын шилэн дансны цахим хуудас нь :

- 1.төсөв/ гүйцэтгэл
- 2.хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт
- 3 бусад гэсэн гурван дэд цэстэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт, төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээ, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг дараа сарын 08-ны өдөр байршуулна гэж заасны дагуу 2022 оны 01 дүгээр сарын цахим мэдээллийг 02 дугаар сарын 07, 02 дугаар сарын цахим мэдээллийг 03 дугаар сарын 01, 03 дугаар сарын мэдээллийг 04 дүгээр сарын 02-ны өдөр тус тус бүрэн байршуулсанаар хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нэг. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар

ХХААГ-ын 2022 оны батлагдсан төсөв 219553.9 мянган төгрөг, ХХААХҮЯ-ны 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/460 дугаар албан тоотын дагуу төсөв 217119.7 мянган төгрөг буюу 2434.2 мянган төгрөгөөр буурч батлагдсан. Энэ нь МУ-ын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчөлт орсноор төсвийн зарлага, санхүүжилт шинэчлэгдсэн.

Төсвийн гүйцэтгэлийн талаар: Энэ цэсэнд шалгуур үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт, гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт, төсөв хэтэрсэн болон хэмнэсэн болон холбогдох шалтгаан тайлбарыг гүйцэтгэлийн мэдээллээр бүрэн илэрхийлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасан мэдээлэлтэй нийцэж байна. Мэдээллийг сар бүрээр нь авч үзвэл:

**1 дүгээр сард** Нийт зардлын дүн гүйцэтгэлийн мэдээллээр 17460363 төгрөг, шилэн дансны мэдээгээр зөрүүгүй, цалин хөлс урамшууллын зардал 14755997 төгрөг, ажил

олгогчоос НД-д төлөх шимтгэл 1860983 төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 804858 төг, хангамж бараа материалын зардал 38525 төгрөг, албан томилолт 0 төг, ажил олгогчоос тэтгэмж урамшууллын зардал 0 төгрөг. Гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээлэл зөрүүгүй.

**2 дугаар сард** Нийт зардлын дүн 36409611 төгрөг, цалин хөлс урамшууллын зардал 30110000 төгрөг, ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл 3763800 төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 1596038 төгрөг, хангамж бараа материалын зардал 463250 төгрөг, албан томилолт 0 төг, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчлгээ 220123 төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал 256400 төгрөг. Гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээлэл зөрүүгүй.

**3 дугаар сард** Нийт зардлын дүн гүйцэтгэлийн мэдээллээр 54759760 төгрөг, шилэн дансны мэдээлэл зөрүүгүй, цалин хөлс урамшууллын зардал 45165000 төгрөг, ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл 5645700 төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 2522000 төгрөг, хангамж бараа материалын зардал гүйцэтгэлийн мэдээллээр 889100 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 710000 төгрөг, эд хогшил урсгал зардал 141200 төгрөг, албан томилолт 28200 төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал 256400 төгрөг .

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар зардлын нийт дүн төлөвлөгөөтэй харьцуулахад 597840 төгрөгөөр хэмнэгдсэн /төл 55357600 төг, гүйц 54759760 төг /.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлтүүд гүйцэтгэлийн мэдээгээр	Сараар			Төл-гөө	Хэтрэлт хэмнэлт
		1	2	3		
1	Нийт зардлын дүн	17460363	36409611	54759760	55357600	597840 хэмнэлт
2	Цалин хөлс урамшуулал	14755997	30110000	45165000	45165000	-
3	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	1860983	3763800	5645700	5645700	-
4	Байр аш-тай холбоотой зардал	804858	1596038	2399637	2522000	122363 хэмнэлт
5	Хангамж бар.мат зардал	38525	463250	889100	889100	-
6	Бараа үйлчилгээний бусад зардал	-	220123	235123	710000	474877 хэмнэлт
7	Эд хогшил,урсгал зардал			140600	141200	600 хэмнэлт

7	Томилолт	-	-	28200	28200	-
8	Бусдаар гүйцсэн ажил үйлчлэл	-	-	-	-	-
9	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	-	256400	256400	256400	-
10	Урсгал зардал	-	-			

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтын дагуу худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гэрээ, төлбөрийн хүсэлт, нэхэмжлэх “И” баримт зэргийг сар бүр цахимд бүрэн байршуулсан байна.

2022 оны 1 дүгээр сард 2008383 төгрөгийн зардлын гүйлгээ, 2 дугаар сард 1136700 төгрөгийн зардлын гүйлгээ, 3 дугаар сард 962800 төгрөг. 1 дүгээр улирлын байдлаар 4107883 төгрөгийн зардлын гүйлгээг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэх “И” баримтын хамт шивсэн байна.

Хүснэгтээр харуулбал:

Дд	Он\сар	Байгууллагын нэр	Зардлын дүн / төгрөг/
1	I	Гс Тохижилт- сүмбэр	8000
2		БЗӨБЦТС ТӨХК гэрэл цахилгааны төлбөр	85858
3		Монгол шуудан шуудангийн зардал	30525
		Ус-Ду халаалтын зардал	719000
		“Анар үйлс” ХХКхмадуудад хүндэтгэл үзүүлэх	1165000
1 сарын гүйлгээ хийгдсэн дүн			2008383
1	II	“Анар үйлс” ХХК	143200
2		Алхана трейд ХХК тээвэр шатахууны үнэ	279500
3		Ус-Ду халаалтын зардал	714000
2 сарын гүйлгээ хийгдсэн дүн			1136700
1	III	Алхана трейд ХХК тээвэр шатахууны үнэ	130000
2		“Анар үйлс” ХХК	118800
3		Ус-Ду халаалтын зардал	714000
3 сарын гүйлгээ хийгдсэн дүн			962800
I улирлын дүн			4107883

2022 оны 1-р улиралд үндсэн үйл ажиллагааны орлого 55409100 төгрөгийн санхүүжилт төвлөрсөнөөс, 2 дугаар сард 51500 /тээвэр шатахуун 19500 төг, шуудан холбоо 19000 төг, хог хаягдал 8000 төг, цэвэр, бохир ус 5000 /төгрөгийг буцаан татаж санхүүжилт 55357600 төгрөг болсон.

Байгууллагын хэмжээнд 1 дүгээр улирлын байдлаар авлага /байгууллагаас авах авлага/ 5400000 төгрөг, өглөг 1717218 төгрөг / Ажил олгогчоос төлөх НДШ 5645700 төгрөг, түлш халаалт 2052000 төгрөг, шуудан холбоо 259000 төгрөг, тээвэр шатахуун 409500 төгрөг, хог хаягдал 38000 төгрөг, томилолт 28200 төгрөг, тэтгэмж урамшуулал 256400 төгрөг /

Санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

Сар	Гүйцэтгэлийн мэдээлэл /үндсэн баримтаар/	Шилэн дансны мэдээлэл	Дүн
1	18111200	-	18111200
2	18757400-51500 /санхүүжилт татсан/ =18705900	-	18705900
2	256400	-	256400
3	18284100	-	18284100
Дүн	55409100-51500= 55357600		55357600

Өр, авлагын мэдээ:

Үзүүлэлт		1 сар	2 сар	3 сар
Авлага	Эхний үлдэгдэл	7200000	6600000	6000000
	Эцсийн үлдэгдэл /төг/	6600000	6000000	5400000
Өглөг	Эхний үлдэгдэл	253636	253636	1333178
	Эцсийн үлдэгдэл /төг/	253636	1333178	1717218

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын дагуу /жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор шилэн дансанд оруулах/ 2021 оны Төсөв/ гүйцэтгэл цэсний санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт мэдээлэлд 2022 оны 02 дугаар сарын 28-нд “Аудитын санал дүгнэлт, 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан тайланг” PDF хэлбэрээр байршуулсан.

Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт:

Хоёр.Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт:

2.1 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын дагуу хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт байхгүй.

2.2 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтын дагуу таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гэрээ, санхүүжилтийн хэмжээ,

нийлүүлэгчийн нэр, хаягыг бүрэн мэдээлнэ; Энэ нь 6.4.5 дахь зарлагыг өссөн дүнгээр тусгана.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар худалдан авсан бараа, ажил үйлчилгээг хүснэгтээр харуулбал: 3 дугаар сард өссөн дүнгээр бараа материалд 1427000 төгрөг, шатахуунд 409500 төгрөг, түлш, халаалт цэвэр бохир усны төлбөрт 2147000 төгрөг, нийт 3983500 төгрөгийн бараа, ажил үйлчилгээний зардал гарсан байна. Худалдан авсан бараа ажил үйлчилгээг сар, сараар хүснэгтээр харуулбал:

1 дүгээр сард худалдан авсан бараа ажил үйлчилгээ:

Д\д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр	Санхүүжилт /өссөн дүнгээр/	Бараа ажил үйлчилгээ нийлүүлэгч
1	Түлш халаалт цэвэр бохир усны төлбөр	719000	Ус-Ду ОНӨҮГ
2	Бараа материал худалдан авах	1165000	Анар үйл ХХК
Дүн		1884000	

2 дугаар сард худалдан авсан бараа, ажил үйлчилгээ:

Д\д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр	Санхүүжилт /өссөн дүнгээр/	Бараа ажил үйлчилгээ нийлүүлэгч
1	Бараа материал худалдан авах	1308200	Анар үйл ХХК
1	Шатахуун	279500	Алхана трейд
2	Түлш халаалт цэвэр бохир усны төлбөр	1433000	Ус-Ду ОНӨҮГ
Дүн		3020700	

3 дугаар сард худалдан авсан бараа, ажил үйлчилгээ /өссөн дүнгээр/:

Д\д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр	Санхүүжилт /өссөн дүнгээр/	Бараа ажил үйлчилгээ нийлүүлэгч
1	Бараа материал худалдан авах	1427000	Анар үйл ХХК
1	Шатахуун	409500	Алхана трейд
2	Түлш халаалт цэвэр бохир усны төлбөр	2147000	Ус-Ду ОНӨҮГ
Дүн		3983500	



2.3 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтын дагуу цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг хүснэгтээр харуулбал нийт санхүүжилт , 1 дүгээр улиралд 55409100 төгрөг, бараа үйлчилгээний зардалд 4107883 төгрөг байна. Үүнийг сар, сараар харуулбал:

1 дүгээр сард :

Дд	Огноо	Харилцагч байгууллага	Орлого	Зарлага	Гүйлгээний утга
1	2022.01.07	Сангийн яам	18111200		Санхүүжилт
2	2022.01.25	БЗӨБЦТС ТӨХК		85858	Гэрэл цахилгааны төлбөр
3	2022.01.25	Гс Тохижилт-Сүмбэр		8000	Хог хаягдлын төлбөр
4	2022.01.25	Монгол шуудан		30525	Шуудангийн зардал
Дүн				124383	

2 дугаар сард :

Дд	Огноо	Харилцагч байгууллага	Орлого	Зарлага	Гүйлгээний утга
1	2022.02.08	Сангийн яам	18757400		Санхүүжилт
2	2022.02.08	Сангийн яам	256400		Санхүүжилт
3	2022.01.25	Ус-Ду		719000	Түлш халаалт цэвэр бохир ус
4	2022.01.28	Анар үйлс ХХК		1165000	Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх /мат үнэ/
5	2022.02.09	Анар үйлс ХХК		79400	Бараа үйлчилгээний төлбөр
6	2022.02.15	Анар үйлс ХХК		63800	Цэвэрлэгээний материал
7	2022.02.15	Алхана трейд ХХК		207000	Шатахууны зардал
8	2022.02.17	Алхана трейд ХХК		72500	Шатахууны зардал
9	2022.02.23	Ус-Ду		714000	Түлш халаалт цэвэр бохир ус
Дүн			19013800	3020700	

3 дугаар сард :

Дд	Огноо	Харилцагч байгууллага	Орлого	Зарлага	Гүйлгээний утга
1	2022.03.07	Сангийн яам	18284100		Санхүүжилт

2	2022.03.09	Ус-Ду		64570	Түлш халаалт цэвэр бохир ус
3	2022.03.16	Алхана трейд ХХК		130000	Шатахууны зардал
4	2022.03.16	Анар үйлс ХХК		95700	Бичиг хэрэг
5	2022.03.06	Анар үйлс ХХК		23100	Цэвэрлэгээний материал
6	2022.03.22	Ус-Ду		649430	Түлш халаалт цэвэр бохир ус
Дүн			18284100	962800	

Гурав. Бусад:

3.1 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр заалтын дагуу 1-3 сарын хугацаанд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл тайлбар 17 гарсныг холбогдох албан тушаалтнаас авч цахимд бүрэн байршуулсан байна.

3.2 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 6.8.1 дэх заалтын дагуу 1 дүгээр улирлын байдлаар ХХААГ-ын даргын “А” тушаал 10, “Б” тушаал 11, үйл ажиллагаатай холбоотой байгуулсан 4 гэрээг цахимд бүрэн байршуулав.

2022 оны 01 сард гарсан шийдвэр, цахимд байршуулсан гэрээ:

Д/д	Шийдвэр гаргагч	Огноо	Шийдвэрийн дугаар	Шийдвэрийн утга
1	ХХААГ-ын дарга	2022.01.13	Б\01	Л.Алдарыг албан тушаалд томилох тухай
2	ХХААГ-ын дарга	2022.01.14	Б\02	Буцалтгүй тусламж олгох тухай
3	ХХААГ-ын дарга	2022.01.14	Б\03	А.Баярмаагийн албан тушаалын цалингийн сүлжээний шатлал ахиулах тухай
4	ХХААГ-ын дарга	2022.01.14	Б\04	Б.Мэндбаярын албан тушаалын цалингийн сүлжээний шатлал ахиулах тухай
5	ХХААГ-ын дарга	2022.01.14	Б\05	Д.Нямсэржийг албан тушаалд томилох тухай
6	ХХААГ-ын дарга	2022.01.14	Б\06	Т.Долгормаагийн албан тушаалын цалингийн шатлал ахиулах тухай
7	ХХААГ-ын дарга	2022.01.14	Б\07	Д.Балжиннямын албан тушаалын цалингийн сүлжээний шатлал ахиулах тухай
8	ХХААГ-ын дарга	2022.01.14	Б\08	Д.Төрмөнхийн албан тушаалын цалингийн шатлал ахиулах тухай ,
9	ХХААГ-ын дарга	2022.01.17	А\01	Бүтэц орон тоо батлах тухай
10	ХХААГ-ын дарга	2022.01.17	А\02	Ээлжийн амралтын хуваарь батлах тухай Ээлжийн амралтын

				хуваарь батлах тухай
11	ХХААГ-ын дарга	2022.01.19	А\03	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай
12	ХХААГ-ын дарга	2022.01.25	А\04	Нөхөн төлбөр олгох тухай
13	ХХААГ-ын дарга	2022.01.25	А\05	Хөрөнгө зарцуулах тухай
14	ХХААГ-ын дарга	2022.01.25	А\06	Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай
15	ХХААГ-ын дарга	2022.01.25	А\07	Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх тухай
16	ХХААГ-ын дарга	2022.01.25	Б\09	С.Мөнхжаргалд чөлөө олгох тухай
17	Ус-Ду	2022.01.01	№01	Дулаан эрчим хүч хэрэглээний халуун, хүйтэн усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ. /2 жилийн хугацаатай/
18	Шуудан холбооны газар	2022.01.01	№02	Шуудангийн үйлчилгээ үзүүлэх гэрээ
19	Алхана трейд	2022.01.03	№03	Талоноор шатахуун нийлүүлэх гэрээ
20	Анар үйлс ХХК	2022.01.03	№04	Бараа материал бэлтгэн нийлүүлэх гэрээ
21	ХХААГ-ын дарга	2022.01.31	Б\10	Л.Энхчимэгийг албан тушаалд түр томилох тухай

2021оны 02 сард гарсан шийдвэр, цахимд байршуулсан гэрээ:

Д/д	Шийдвэр гаргагч	Огноо	Шийдвэрийн дугаар	Шийдвэрийн утга
1	ХХААГ-ын дарга	2022.02.17	Б\11	Буцалтгүй тусламж олгох тухай
2	ХХААГ-ын дарга	2022.02.21	А\08	Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай
3	БЗӨБЦТС ТӨҮГ	2022.02.22	№ 309426	Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ

2021оны 03 сард гарсан шийдвэр, цахимд байршуулсан гэрээ:

Д/д	Шийдвэр гаргагч	Огноо	Шийдвэрийн дугаар	Шийдвэрийн утга
1	ХХААГ-ын дарга	2022.03.23	А\09	Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай
2	ХХААГ-ын дарга	2022.03.23	А\10	Хөрөнгө зарцуулах тухай
3	Хас эрин орчин ХХК	2022.03.01	№110	Програм хангамж, ашиглалтын гэрээ
4	Ус-Ду	2022.01.03	№05	Дулаан эрчим хүч хэрэглээний халуун, хүйтэн усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ/1 жилийн хугацаатай/

3.3 Хуулийн 6.4.7 дахь заалтын дагуу 1-3 сарын хугацаанд тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт байхгүй.

3.4 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7 заалтын дагуу батлагдсан орон тоо, орсон өөрчлөлтийн дагуу мэдээллийг байршуулж сул орон тооны захиалгыг аймгийн ТЗУХ-т хүргүүлсэн байна. 2022 онд батлагдсан орон тоо 17 үүнээс ТЗ-10, ТҮ-7 албан хаагч. 1-3 сарын байдлаар 16 орон тоотойгоор ажилласан.

3.5 Шилэн дансны журмын дагуу 1-3 сарын хугацаанд худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн талаарх мэдээлэл гараагүй байна.

### ХХААГ-ЫН ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМД БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЭЛД 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ДОТООД АУДИТ ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ДҮГНЭЛТ

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын шилэн дансны цахим мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол ХХААГ-ын даргын баталсан 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 02 тоот удирдамжийн хүрээнд шалгав.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар үндсэн үйл ажиллагааны орлого 55357600 төгрөгийн санхүүжилт авсан.

Байгууллагын хэмжээнд 1 дүгээр улирлын байдлаар авлага 5400000 төгрөг, өглөг 1717218 төгрөг.

Мөн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл тайлбар 17 гарсныг холбогдох албан тушаалтнаас авч цахимд мэдээлсэн.

Оны эхэнд аж ахуй нэгж бусад байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ болон төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан эрх бүхий албан тушаалтны шийдвэр 21 гарсныг тухай бүр байршуулсан байна. Нийт 6 байгууллагатай / Ус-Ду ОНӨҮГ, Алхана трейд, БЗӨБЦТС ТӨҮГ, Шуудан холбооны газар, Анар үйлс ХХК, Хас эрин орчин ХХК, / хамтран ажиллах 7 гэрээг байгуулсан.

Байгууллагын 2021 оны шилэн дансны мэдээлэлд дутуу оруулсан цэсний мэдээллийг бүрэн байршуулав. Энэ нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтын

дагуу таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гэрээ, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг бүрэн мэдээлнэ гэсэн заалтын дагуу 6.4.5 дахь зарлагыг өссөн дүнгээр тусгав.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар бараа материалд 1427000 төгрөг, шатахуунд 409500 төгрөг, түлш, халаалт цэвэр бохир усны төлбөрт 2147000 төгрөг, нийт 3983500 төгрөгийн бараа, ажил үйлчилгээний зардал гарсан.

Шилэн дансны цахим мэдээллийг хуулийн хугацаанд цэс болгоноор бүрэн оруулсан байна. Нийт 37 мэдээллийг хугацаанд нь 100 хувь оруулсан. Байгууллагын шилэн дансны цахим мэдээлэлтэй холбоотой гарсан зөрчил, дутагдал байхгүй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН :

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАГИЙН АХЛАГЧ :

ГИШҮҮД:

С. МӨНХЖАРГАЛ

Э. ТҮВШИНЗАЯА

А. БАЯРМАА

